



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 11 сарын 28 өдөр

Дугаар А/А60

Булган сум

**Засаг даргын дэргэдэх мэдээллийн технологийн
"Хурдан" клуб байгуулах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, 15.1.2, 21.1.4 дэх заалт Монгол Улсын Улсын Их хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 5.3 заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Алсын хараа-2050", Шинэ сэргэлтийн бодлогод тусгагдсан "Цахим үндэстэн" болох арга хэмжээг эрчимжүүлж, ахлах ангийн сурагчдын мэдээлэл технологийн ур чадварыг дээшлүүлж, цахим ур чадвартай иргэдийг нэмэгдүүлэх, хүний нөөцийн хөгжлийг дэмжих зорилгоор мэдээлэл технологийн "Хурдан" клубийг Засаг даргын дэргэд байгуулсугай.

2. Мэдээлэл технологийн ур чадварыг дээшлүүлэх "ХУРДАН" клубийг удирдлага зохион байгуулалт, арга зүйгээр хангаж ажиллахыг Булган аймаг дахь Төрийн цахим үйлчилгээний хэлтсийн дарга (Н.Булган)-д даалгасугай.

3. Тус клубийн үйл ажиллагааг идэвхжүүлж, дэмжлэг үзүүлэн хамтран ажиллахыг агентлаг, байгууллагын дарга нар, сумын Засаг дарга нарт тус тус даалгасугай.

5. Хурдан клубийн үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Д.ПҮРЭВ-ОЧИР